

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА БӨГӨӨД
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 03 дугаар сарын 06

Дугаар А/33

Улаанбаатар хот

Худалдан авах ажиллагааны
ил тод байдлыг хангах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4 дэх хэсэг, 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсэг, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.4.10 дахь заалт Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 49 дүгээр тогтоол, Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 56 дугаар тогтоол, Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны ээлжит есдүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оны Авлигатай тэмцэх жил болгон зарлаж, авлигатай тэмцэх таван үйл ажиллагааг эхлүүлсний дагуу Шил ажиллагааны хүрээнд Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, 2023 онд зохион байгуулах худалдан авах ажиллагааны жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.2023 онд зохион байгуулах худалдан авах ажиллагааны жагсаалтыг Хурлын цахим хуудсанд байршуулан, сонгон шалгаруулалтыг нээлттэй зохион байгуулах арга хэмжээ авч, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн дарга (М.Чанцалням)-д даалгасугай.

ДАРГА

Ч.МЭНДСАЙХАН

Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны даргын 2023 оны дугаар сарын-ны өдрийн дугаар тушаалын хавсралт

Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албанаас 2023 онд зохион байгуулах худалдан авах ажиллагааны жагсаалт

| Д/д | Төсөл, арга хэмжээний жагсаалт | Хугацаа | | Төсөвт өртөг (төгрөгөөр) | 2023 онд санхүүжих дүн (төгрөгөөр) |
|----------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------|--------|--------------------------|------------------------------------|
| | | эхлэх | дуусах | | |
| 1 | Баянзүрх дүүргийн өсвөр үе, залуучуудын хөгжлийг дэмжих, сургагч багшаар бэлтгэх цогц хөтөлбөр хэрэгжүүлэх зөвлөх үйлчилгээ | 2023 | 2023 | 150,000,000 | 150,000,000 |
| 2 | Монгол ахуй төсөл | 2023 | 2023 | 100,000,000 | 100,000,000 |
| 3 | Хурлын хуралдааны цахим программ хөгжүүлэх зөвлөх үйлчилгээ | 2023 | 2023 | 50,000,000 | 50,000,000 |
| 4 | Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрийн дунд хугацааны хөгжлийн бодлогыг нэмэлт агуулгаар баяжуулан шинэчлэн боловсруулж хэвлэх, англи хэл рүү орчуулан хэвлэх, дүүргийн ИТХ-ын түүхэн товчоон хийх зөвлөх үйлчилгээ | 2023 | 2023 | 124,000,000 | 124,000,000 |
| Нийт дүн | | | | | 424,000,000 |